

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТӨРӨЛЖСӨН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЯМБА, ДАРХАН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН XV ХАВСРАЛТЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс “Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенц”-д 1970 оны 03 дугаар сарын 03-ны өдөр нэгдэн орсон. Тухайн үед Дэлхийн оюуны өмчийн байгууллага (ДОӨБ) НҮБ-ын төрөлжсөн байгууллагын статусгүй байсан бөгөөд 1974 оны 12 дугаар сарын 17-ны өдөр ийм статустай болохыг нь дээрх конвенцын XV хавсралтаар тогтоосон болно.

Монгол Улс Дэлхийн оюуны өмчийн байгууллагад 1979 онд гишүүнээр элсэн орсон боловч “Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенц”-ын ДОӨБ-ын хувьд хамаарах XV хавсралтыг соёрхон батлаагүй байна.

Уг конвенц ёсоор улс орнууд НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын холбогдох чиг үүргээ үр ашигтай хэрэгжүүлэхэд чухал эрх ямба, дархан эрхийг хүлээн зөвшөөрөх учиртай. Үүнд төрөлжсөн байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглахаар импортлох буюу экспортлох эд зүйлсийн хувьд шууд татвар, гаалийн татвар болон импорт, экспортын хязгаарлалтаас чөлөөлөх, тухайн байгууллагын чиг үүргийн хүрээнд албан тушаалын дагуу хэлсэн, бичсэн үг, үйлдлийн хувьд эрх зүйн ажиллагаанаас чөлөөлөх, тухайн байгууллагын эд хөрөнгө халдашгүй байх зэрэг эрх ямба, дархан эрх багтана.

Монгол Улс ДОӨБ-д элссэн цагаас хойш тус байгууллагын удирдан хэрэгжүүлдэг нийт 26 гэрээ хэлэлцээрийн 16-д нэгдэн орсон. Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газар нь ДОӨБ-тай олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүргийн биелэлтийг хангах, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, албан хаагчдыг сургах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV хавсралтыг соёрхон баталснаар ДОӨБ Монгол Улсад чиг үүргээ хэрэгжүүлэх, мөн Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид ДОӨБ-ын чиглэлээр томилогдон ажиллахад эдлэх эрх ямба, дархан эрх олон улсын эрх зүйн үндэслэлтэй болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТӨРӨЛЖСӨН БАЙГУУЛЛАГЫН
ЭРХ ЯМБА, ДАРХАН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН
XV ХАВСРАЛТЫН ТУХАЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

1. “Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенц”-оор НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, тэдгээрийн албан тушаалтнууд, гишүүн улсын төлөөлөгчид чиг үүргээ үр ашигтай хэрэгжүүлэхэд чухал эрх ямба, дархан эрхийг олгодог.

1. Төрөлжсөн байгууллага тухайлбал дараах эрх ямба, дархан эрх эдэлнэ:

- төрөлжсөн байгууллага нь хуулийн этгээд байх бөгөөд тухайн байгууллага болон эд хөрөнгө нь эрх зүйн ажиллагаа, нэгжлэг, хураан авалт гэх мэт гүйцэтгэх, захиргааны, шүүхийн үйл ажиллагаанаас чөлөөлөгдөнө;

- төрөлжсөн байгууллагын байр, архив, баримт бичиг халдашгүй байна;

- төрөлжсөн байгууллага нь хөрөнгө, алт, валютыг эзэмшиж, хөдөлгөж, шилжүүлж, хөрвүүлж болно;

- төрөлжсөн байгууллага, түүний хөрөнгө, орлого, бусад эд хөрөнгө шууд татвараас чөлөөлөгдөнө, албан хэрэгцээнд ашиглахаар импортлох буюу экспортлох эд зүйлсийн хувьд гаалийн татвар болон импорт, экспортын хязгаарлалтаас чөлөөлөгдөнө; хэвлэл нийтлэл нь импорт, экспортын хураамж, хориглолт, хязгаарлалтаас чөлөөлөгдөнө;

- онцгой албан татвар болон хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө худалдсаны үнэд багтах татвараас чөлөөлөхийг шаардахгүй хэдий ч албан хэрэгцээнд зориулан хийсэн чухал худалдан авалтын хувьд уг конвенцын оролцогч улс нь уг татварыг буцаан олгох талаар захиргааны зохих арга хэмжээ авна;

- оролцогч улсын нутаг дэвсгэрт албан харилцаандаа тухайн улс бусад улсад (түүний дотор дипломат төлөөлөгчийн газарт нь) олгодгоос дутуугүй нөхцлийг олгоно;

- төрөлжсөн байгууллагын албан ёсны захидал харилцаанд хяналт тавихгүй, төрөлжсөн байгууллага нь код хэрэглэх, захидал харилцааг элчээр буюу лац бүхий шуудангаар (дипломаттай адил) илгээх эрхтэй, чингэхдээ оролцогч улс ба төрөлжсөн байгууллагын хооронд хэлэлцээр байгуулж аюулгүй байдлын арга хэмжээг тогтоож болно.

2. Төрөлжсөн байгууллагын гишүүн улсын төлөөлөгч уг байгууллагын хуралд оролцох үеэр болон очих, буцах замдаа дараах эрх ямба, дархан эрх эдэлнэ:

- баривчлах буюу саатуулах, хувийн ачааг нь хураан авахаас, мөн албан тушаалынхаа хувьд хэлсэн, бичсэн үг, хийсэн үйлдэлдээ эрх зүйн ямарваа ажиллагаанаас чөлөөлөгдөх, чингэхдээ хэлсэн, бичсэн үг, хийсэн үйлдэлдээ эдлэх дархан эрх нь тухайн этгээд уг үүргээ гүйцэтгэхээ больсны дараа ч хэвээр байна;

- ажил хэргийн материал, баримт бичиг халдашгүй байх;

- код хэрэглэх, захидал харилцааг элчээр буюу лац бүхий шуудангаар хүлээж авах;

- өөрөө болон эхнэр/нөхөр нь хилийн хязгаарлалт, гадаадын иргэний бүртгэл, тухайн очсон эсхүл дамжин өнгөрч буй улсын иргэний үүргээс чөлөөлөгдөх;

- албан түр томилолтоор яваа гадаад улсын төлөөлөгчдөд олгодогтой адил валютын болон валют солилцооны хязгаарлалтаас чөлөөлөгдөх;
- хувийн ачааны хувьд дипломат төлөөлөгчийн газрын дүйцэх зиндааны гишүүдэд олгодогтой адилаар дархан эрх, хөнгөлөлт эдлэх;
- татварын аливаа асуудлыг шийдвэрлэхэд оршин суух шаардлага тавих тохиолдолд төрөлжсөн байгууллагын хуралд оролцох хугацааг оруулахгүй;

Дээрх эрх ямба, дархан эрх нь гишүүн улсын эрх баригчдад хамаарахгүй.

Үүнээс гадна дээрх эрх ямба, дархан эрхийг гишүүн улсын төлөөлөгчийн хувийн ашиг тусын тулд биш, чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэхийг дэмжих зорилгоор олгодог. Тиймээс гишүүн улс уг дархан эрх нь шударга ёсонд нийцэхгүй гэж үзвэл төлөөлөгчийнхөө дархан эрхээс татгалзах эрх, үүрэгтэй.

3. Төрөлжсөн байгууллагын албан тушаалтан тухайлбал дараах эрх ямба, дархан эрх эдэлнэ:

- албан тушаалынхаа хувьд хэлсэн, бичсэн үг, хийсэн үйлдэлдээ эрх зүйн ямарваа ажиллагаанаас чөлөөлөгдөх;
- төрөлжсөн байгууллагаас олгодог цалин, хөлсний хувьд НҮБ-ын албан тушаалтнуудтай адил татвараас чөлөөлөгдөх болон бусад нөхцлийг эдлэх;
- өөрөө болон эхнэр/нөхөр, асрамжид байгаа хүмүүс нь хилийн хязгаарлалт, гадаадын иргэний бүртгэлээс чөлөөлөгдөх;
- валют солилцооны хөнгөлөлтийн хувьд дипломат төлөөлөгчийн газрын дүйцэх зиндааны албан тушаалтнуудад олгодогтой адил эрх ямба эдлэх;
- өөрөө болон эхнэр/нөхөр, асрамжид байгаа хүмүүс нь олон улсын хямралын үед буцахдаа дипломат төлөөлөгчийн газрын дүйцэх зиндааны албан тушаалтнуудад олгодогтой адил дэмжлэг авах;
- тухайн улсад томилогдон анх очихдоо тавилга, эд хогшлыг татваргүйгээр оруулах;
- тухайн улсын иргэн байх тохиолдолд тухайн төрөлжсөн байгууллагаас гаргаж тухайн улсаар батлуулсан жагсаалтад нэр нь орсон бол иргэний үүргээс чөлөөлөгдөх бөгөөд иргэний үүрэгт дуудагдах тохиолдолд төрөлжсөн байгууллагын хүсэлтээр дуудлагыг хойшлуулж болно.

Төрөлжсөн байгууллагын гүйцэтгэх дээд албан тушаалтан буюу түүний эзгүйд үүрэг гүйцэтгэгч болон тэдний эхнэр/нөхөр, бага насны хүүхэд нь дээрх эрх ямба, дархан эрхээс гадна олон улсын эрх зүйн дагуу дипломат элчид олгодог эрх ямба, дархан эрх, чөлөөлөлт, хөнгөлөлтийг эдлэнэ.

Үүнээс гадна дээрх эрх ямба, дархан эрхийг албан тушаалтны хувийн ашиг тусын тулд биш, төрөлжсөн байгууллагын эрх ашгийн тулд олгодог. Тиймээс төрөлжсөн байгууллага уг дархан эрх нь шударга ёсонд нийцэхгүй гэж үзвэл албан тушаалтныхаа дархан эрхээс татгалзах эрх, үүрэгтэй. Албан тушаалтных нь дээрх эрхтэй холбоотойгоор төрөлжсөн байгууллага нь гишүүн улсын эрх бүхий байгууллагатай хамтран ажиллана.

4. Конвенцод мөн эрх ямба, дархан эрхтэй холбоотой бусад зохицуулалтыг тусгаснаас дурдвал:

Хэрэв эрх ямба, дархан эрхийг буруугаар ашигласан гэж гишүүн улс үзсэн бол тухайн улс ба төрөлжсөн байгууллагын хооронд зөвлөлдөнө. Ийнхүү зөвлөлдөөд үр дүнд хүрэхгүй бол асуудлыг Олон улсын шүүхэд шилжүүлэх бөгөөд ОУШ эрх ямба, дархан эрхийг буруугаар ашигласан гэж тогтоовол тухайн улс уг эрх ямба, дархан эрхийг түдгэлзүүлнэ.

Гишүүн улсын төлөөлөгчийг албан тушаалынхаа хүрээнд явуулсан үйл ажиллагаатай нь холбогдуулж очсон улсаас нь гарахыг шаардаж болохгүй, харин албаны чиг үүргээсээ гадуурх үйл ажиллагааны улмаас тухайн улсад байхтай холбоотой эрх ямбаа буруугаар ашигласан бол гарахыг шаардаж болно. Чингэхдээ гишүүн улсын төлөөлөгч болон гүйцэтгэх дээд албан тушаалтан буюу түүний эзгүйд үүрэг гүйцэтгэгч болон тэдний эхнэр/нөхөр, бага насны хүүхдийн хувьд тухайн улсад томилогдсон дипломат элчид хамаардаг журам үйлчилнэ. Бусад албан тушаалтны хувьд төрөлжсөн байгууллагын гүйцэтгэх дээд албан тушаалтантай зөвлөлдсөний дараа тухайн улсын гадаад хэргийн сайдын зөвшөөрлөөр гаргах шаардлагыг тавих бөгөөд уг гүйцэтгэх дээд албан тушаалтан тухайн албан тушаалтантай холбогдох ажиллагаанд түүнийг төлөөлж оролцох эрхтэй байна.

Төрөлжсөн байгууллагын албан тушаалтнууд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга ба тухайн төрөлжсөн байгууллагын эрх бүхий албан тушаалтны хооронд тохиролцсоны дагуу НҮБ-ын *laissez-passer* ашиглах эрхтэй бөгөөд гишүүн улсууд *laissez-passer*-г хүлээн зөвшөөрнө. *Laissez-passer* бүхий албан тушаалтны, түүнчлэн *laissez-passer* байхгүй ч төрөлжсөн байгууллагын ажлаар аялж буй шинжээч ба бусад этгээдийн визийн хүсэлтийг түргэн шийдвэрлэнэ.

Төрөлжсөн байгууллагын гүйцэтгэх дээд албан тушаалтан, гүйцэтгэх дээд туслах албан тушаалтан, газрын дарга, газрын даргаас доошгүй зиндааны бусад албан тушаалтан НҮБ-ын *laissez-passer* ашиглан албан ажлаар аялж буй тохиолдолд тэдэнд дипломат төлөөлөгчийн газрын дүйцэх зиндааны албан тушаалтанд олгодогтой адил аяллын нөхцөл олгоно.

Төрөлжсөн байгууллага тус бүр гэрээнээс үүссэн болон хувийн чанартай маргаан, мөн дархан эрх бүхий албан тушаалтантай холбоотой маргааныг шийдвэрлэх арга замаа тодорхойлдог. Конвенцыг тайлбарлах, хээглэхтэй холбоотой саналын зөрүүг ОУШ-д шилжүүлнэ.

II. “Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенц”-ын XV хавсралтаар уг конвенцын “жишиг заалт” буюу эрх ямба, дархан эрхийн тухай заалтыг НҮБ-ын төрөлжсөн байгууллага болох Дэлхийн оюуны өмчийн байгууллагын онцлогт тохирсон буюу хавсралтад заасан нэмэлт, өөрчлөлтийн хамт хэрэглэхээр заасан.

Мөн гишүүн улс ба төрөлжсөн байгууллагын хооронд нэмэлт гэрээ байгуулж конвенцын заалтыг зохицуулсан эсхүл түүгээр олгосон эрх ямба, дархан эрхийг хязгаарлах боломжтой.

XV хавсралтад дараах нэмэлт өөрчлөлтийг тусгасан:

1) “Төрөлжсөн байгууллагын гүйцэтгэх дээд албан тушаалтан буюу түүний эзгүйд үүрэг гүйцэтгэгч болон тэдний эхнэр/нөхөр, бага насны хүүхэд нь дээрх эрх ямба, дархан эрхээс гадна олон улсын эрх зүйн дагуу дипломат элчид олгодог эрх ямба, дархан эрх, чөлөөлөлт, хөнгөлөлтийг эдлэнэ” гэсэн “жишиг заалт” ДОӨБ-ын Ерөнхий захирлын орлогч нарт мөн хамаарна.

2) (a) ДОӨБ-ын хороодод ажиллах эсхүл албан үүргээр ажиллах шинжээч (дээр заасан албан тушаалтнаас бусад) нарт чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хэмжээнд эдгээр хороодод, эсхүл албан үүргээр ажиллахтай холбоотой аялалд зарцуулах хугацааг хамруулан дараах эрх ямба, дархан эрхийг олгоно. Үүнд:

- (i) баривчлах эсхүл хувийн ачаа тээшийг битүүмжлэн хураахаас чөлөөлөгдөх дархан эрх;
- (ii) албан чиг үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан хэлсэн буюу бичсэн үг эсхүл хийсэн үйлдлийн хувьд эрх зүйн бүх төрлийн ажиллагаанаас чөлөөлөгдөх дархан эрх, чингэхдээ уг дархан эрх нь тухайн хүн ДОӨБ-ын хороонд эсхүл албан үүргээр ажиллахаа больсон хэдий ч хэвээр байна;
- (iii) валютын болон валют солих хязгаарлалт, хувийн ачаа тээшийн хувьд түр албан томилолтоор яваа гадаадын засгийн газрын албан тушаалтанд олгодогтой нэгэн адил хөнгөлөлт;
- (iv) Байгууллагын шугамаар гүйцэтгэж буй ажилд хамаарах ажил хэргийн материал, баримт бичиг халдашгүй байх;
- (v) Байгууллагатай харилцах харилцааны хувьд шифр хэрэглэх болон элч, эсхүл битүүмжилсэн илгээмжийн шуудангаар бичиг баримт, захидал харилцаа хүлээж авах эрх.

Дээрх (iv) болон (v) дахь дэд хэсгийн хувьд “гишүүн улс ба төрөлжсөн байгууллагын хооронд хэлэлцээр байгуулж аюулгүй байдлын арга хэмжээг тогтоож болно” гэсэн зарчим үйлчилнэ.

(b) Дээрх (a) хэсэгт заасан шинжээч нарт эрх ямба, дархан эрхийг тэдний хувийн эрх ашгийн тулд биш харин ДОӨБ-ын ашиг сонирхлын тулд олгоно. ДОӨБ-ын аливаа шинжээчид олгосон дархан эрх нь ДОӨБ-ын үзэж байгаагаар шударга ёсны явцад саад болохоор байгаа бөгөөд уг дархан эрхээс ДОӨБ-ын ашиг сонирхолд харшлахгүйгээр татгалзаж болох аливаа тохиолдолд ДОӨБ тухайн дархан эрхээс татгалзах эрхтэй бөгөөд үүрэгтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР